



МОНГОЛ УЛС
ХӨВСГӨЛ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2024 оны 05 сарын 07 өдөр

Дугаар 1/229

Мөрөн сум

Ажлын хэсэг байгуулах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж түүний удирдлагын тухай хуулийн 60 дугаар зүйлийн 60.1.1, 66 дугаар зүйлийн 66.1, Монгол Улсын Их хурлын 2022 оны 36 дугаар тогтоолыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Малчдын зөвлөлдөх уулзалтаар Хөвсгөл аймаг Органик бүтээгдэхүүн үйлдвэрлэдэг аймаг болох санаачилга гарсантай холбоотой “Хөвсгөл Органик” хөтөлбөр боловсруулан, батлуулах чиг үүрэг бүхий ажлын хэсгийг хавсралтаар баталсугай.

2. Төлөвлөгөөг 2024 оны 2-р дугаар улиралд багтаан боловсруулж хэрэгжилтийг хангаж, үр дүнг Засаг даргын зөвлөлийн хуралд танилцуулахыг ажлын хэсгийн ахлагч (М.Хуягбаатар)-д үүрэг болгосугай.


3. Энэхүү захирамжийн хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Засаг даргын Тамгын газрын дарга (Б.Батбилгүүн)-д үүрэг болгосугай.

ДАРГА



П.ЛХАГВАЖАВ

Аймгийн Засаг даргын 2024 оны 05
дугаар сарын 27-ны өдрийн А/229
дугаар захирамжийн хавсралт



АЖЛЫН ХЭСГИЙН БҮРЭЛДЭХҮҮН

Ажлын хэсгийн ахлагч: Аймгийн Засаг даргын орлогч

Гишүүд : Хөгжлийн бодлого, төлөвлөлт, хөрөнгө оруулалтын хэлтсийн дарга

Мал эмнэлгийн газрын дарга
Эрүүл мэндийн газрын дарга

Цагдаагийн газрын дарга

Стандарт хэмжил зүйн хэлтсийн дарга

Хөдөлмөр халамж үйлчилгээний газар

SFCS органик баталгаажуулалтын компани

/зөвшилцсөнөөр/

Монголын үндэсний худалдаа аж үйлдвэрийн танхимын

Хөвсгөл аймаг дах салбар /зөвшилцсөнөөр/

Хөвсгөл аймгийн хүнсчдийн холбоо /зөвшилцсөнөөр/

Хөвсгөл аймгийн бэлчээр ашиглагчдын холбоо

/зөвшилцсөнөөр/

“Хөвсгөл далай нийгэмлэг” ТББ тэргүүн Ж.Оюумаа
(Биологийн ухааны доктор) /зөвшилцсөнөөр/

Нарийн бичгийн дарга: Аймгийн Хүнс, хөдөө аж ахуйн газрын дарга

-----oOo-----